

**ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР
ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**
/Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2017.07.05

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

2.1 Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 505 заалтыг хяналтанд авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7 тогтоолын 40 заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11 заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

2.2. Өргөдлийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 15 тогтоолын 79 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Өргөдлийн байнгын хорооны 14 тогтоолын 65 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 10 тогтоолын 21 заалт буюу 32.4 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 тогтоолын 19 заалт буюу 29.3 хувь нь хэрэгжих шатандаа, 1 тогтоолын 1 заалт буюу 1.5 хувь хүчингүй болсон, 2 тогтоолын 22 заалт буюу 33.8 хувь хугацаа болоогүй, 1 тогтоолын 1 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 1.5 хувь нь үнэлгээгүй ажил

гэж ирүүлсэн боловч давхардсан тоогоор 10 тогтоолын 24 заалт буюу 30.4 хувийнх нь мэдээг ирүүлээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ӨБХ-ны тогтоол	Заалт	
	/Давхардсан тоогоор/	Тоо	Хувь
Хяналтанд авсан	15	79	100.0
Үүнээс:			
- Хэрэгжсэн	7	15	18.9
- Хэрэгжих шатанд	8	18	22.8
- Хэрэгжээгүй	10	24	30.4
- Үнэлгээгүй	1	1	1.3
- Хугацаа болоогүй	2	21	26.3

2.3. Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

- “Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2013 оны 02 дугаар тогтоолын 1, 2 дахь заалт;
- “Хуулийн заалтыг хэрэгжүүлэх тухай” 2014 оны 03 дугаар тогтоолын 1.4 дэхь заалт;
- “Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар чиглэл өгөх тухай” 2014 оны 05 дугаар тогтоолын 16, 2 дахь заалт;
- “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2014 оны 07 дугаар тогтоолын 1.1, 1.3, 1.4, 1.5, 1.6 дахь заалт;
- “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2014 оны 10 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5 дахь заалт;
- “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2015 оны 11 дүгээр тогтоолын 8, 10 дахь заалт;
- “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2015 оны 12 дугаар тогтоолын 8 дахь заалт;
- “Чиглэл өгөх тухай” 2015 оны 13 дугаар тогтоолын 1 дэх заалт;
- “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2016 оны 16 дугаар тогтоолын /хоёр/ буюу “Тогтоолын биелэлтийг 2016 оны хаврын чуулганд багтаан танилцуулах” үүргээ хэрэгжүүлээгүй;
- “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2016 оны 04 дүгээр тогтоолын 1, 2, 3, 4 дэхь заалтуудын мэдээг ирүүлээгүй байна.

2.4. Бүрэн биелсэн хууль тогтоомжийн зүйл заалтыг хяналтаас хасах тухай

Өргөдлийн байнгын хорооноос баталсан Хавсралт-1-т заасан 7 тогтоолын 15 заалт нь бүрэн хэрэгжиж, мэдээллийн сангийн хяналтаас хасах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн байна.

Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 12 хуудас жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ӨРГӨЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолийн нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар чиглэл өгөх тухай</p> <p align="center">2014.06.03 №: 05</p>	<p>1.1. Хөдөлмөрт бэлтгэх сургалт, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах;</p>	<p>2016 оны байдлаар иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар эзэмшүүлж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажлын байрыг нь дэмжих, үйлдвэрлэл дээр сургасан ажил олгогчид урамшуулах үйл ажиллагаанд 40 мянган хүнийг хамруулснаас 57 хувь нь төгсөлтийн дараа ажлын байртай болсон.</p> <p>Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажиллуулахтай холбоотой гарсан зардлыг ажил олгогчид бүрэн болон хэсэгчлэн нөхөн төлөх, ажил олгогчийн бий болгосон ажлын байранд тухайн иргэнийг тогтвортой урамшуулах зорилго бүхий “Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр”-т 172 хүн, өсвөр залуу үеийнхэнд хөдөлмөрийн хүмүүжил олгох, мэдлэг, туршлагыг өвлүүлэхэд чиглэсэн ахмад мэргэжилтнүүдийн сүлжээ, багийг ажиллуулж, орлогыг нь нэмэгдүүлэх төсөлд 12 мянган хүнийг, орон нутгийн хөгжилд ажилгүй иргэдийн оролцоог хангаж, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг түр хугацаанд орлоготой болгох нийтийг хамарсан ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлж, давхардсан тоогоор 71 мянган хүнийг тус тус хамруулсан.</p> <p>Хорих ангид хөнгөн ял эдэлж буй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх зорилгоор 9 хорих ангийн мянга гаруй хүнд сэтгэл зүйн сургалт зохион байгуулж, МСҮТ, Хөдөлмөрийн хэлтэс хамтран 3.9 мянган хүнд богино хугацаагаар мэргэжил, ур чадвар эзэмшүүлснээс 46 хувьд нь чадамжийн гэрчилгээ, 35 хувьд нь мэргэжлийн үнэмлэх олгогдсон бөгөөд 1.6 тэрбум төгрөгөөр сургалтын орчныг шинэчлэн 8.6 мянган ялтанг гэрээгээр ажиллуулах нөхцлийг бүрдүүлсэн.</p> <p>Өршөөлийн тухай хуулиар суллагдсан 819 иргэнийг нийгэмшүүлж, бизнесийн ур чадвараа эзэмшүүлэх сургалт, зөвлөгөө, мэдээллээр ханган, 50 иргэнийг хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлсэнээр хөдөлмөрийн</p>

		зах зээлд хөл тавих боломжийг дээшлүүлсэн.
	1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад дэмжих;	<p>2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 1956 ажлын байр бий болсон байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр нь 2012 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2016 онд нийт 8 арга хэмжээнд 4626 иргэн /үүнээс Хөгжлийн бэрхшээлтэй 4335/ хамрагдсан байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан нийт 28 аж ахуйн нэгж, ТББ-ууд ажил олгогчийн урамшуулалд хамрагдсан байна.</p> <p>Мөн хөтөлбөрийн хүрээнд 2362 эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж санхүүгийн дэмжлэг болон бусад арга хэмжээнд хамруулсан.</p> <p>2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 1980 ажлын байр бий болсон байна.</p>
	1.5. Орон нутгаас нийслэлд шилжин суурьших хүн амын төвлөрлийг сааруулах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх;	<p>2013 онд Сүхбаатар аймгийн төвд 13 мвт-ын дулааны станц, дулааны шугам, сүлжээг ашиглалтад хүлээн авсан бөгөөд Увс, Ховд, Хөвсгөл аймгийн төвүүдэд дулааны станц, дулааны шугам сүлжээний ажлыг эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн 9 аймгийн төвд дулааны станц барих, шугам сүлжээг нь шинэчлэх, бүх аймагт инженерийн дэд бүтцийг нь шийдсэн жишиг сум бий болгох, 330 суманд бага оврын станц барих зэргээр орон нутгийн хөгжлийг дэмжиж, хүн амын хэт төвлөрлийг сааруулах арга хэмжээ авч байна.</p> <p>2013-2014 онд Өмнөговь аймгийн Ханбогд суманд Оюу толгойн зэс, алтны баяжуулах үйлдвэр, Цогтцэций суманд Ухаа худгийн нүүрс угааж баяжуулах үйлдвэрийн 3-р ээлж, Номгон суманд хар тугалганы баяжуулах үйлдвэр зэрэг 42 үйлдвэр, 2015 онд Дорноговь аймгийн Өргөн суманд цементийн анхны эко үйлдвэрийг ашиглалтад оруулж, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, тэдгээр бүтээн байгуулалтыг дагаж суурьшсан иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд анхаарснаар Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумдад Залуучуудын хөгжлийн төв, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий, Дорноговь аймгийн</p>

			<p>зарим сумдад нийгмийн даатгалын үйлчилгээний бүтцийг бий болгов.</p> <p>Уул уурхайн бүтээн байгуулалтын зэрэгцээ орон нутгийн байгаль орчныг хамгаалах зорилгоор говийн болон баруун бүсийн 9 аймгийн 140 гаруй га газарт бичил уурхайн загвар нөхөн сэргээлтийн төслийг хэрэгжүүлж, цаашид биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардлагатай чадавхи, нөөц боломжийг бүрдүүлэхийг зорьж байна.</p> <p>Хүн амын хэт төвлөрлийг сааруулах үүднээс ажлын байр бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын тусгай сангуудаас Дархан-Уул, Орхон аймгуудад хуваарилах зээлийн хэмжээг нэмэгдүүлж, нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдийн санаачилгыг санхүүгийн хувьд дэмжсэн.</p>
2	<p>Хуулийн заалтыг хэрэгжүүлэх тухай</p> <p>2014.06.03 №: 03</p>	<p>1.3. Төрийн албаны тухай хуулийн 27.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн тухай хуульд тусган батлуулж байх</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам”-ын 1.4-т “Зайлшгүй шаардлагаар гадаад оронд эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг эрүүл мэндийн сайдын төсвийн багцад жил бүр тусгана” гэж заасны дагуу хэрэгжиж байна.</p> <p>Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчилгээ хийлгэсэн тохиолдолд зардлынх нь 60 хувийг төр хариуцаж байна.</p>
		<p>1.4. Төрийн албан хаагчдаас энэ талаар ирсэн гомдлыг судлан үзэж, барагдуулах арга хэмжээ авах</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам”-ын хоёрдугаар зүйлээр уг асуудал зохицуулагдаж байна. Үүнд:</p> <p>Иргэдийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх явц:</p> <p>2.1."Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн жагсаалт"-д орсон өвчин, эмгэгтэй болохыг нь улсын хэмжээний үйлчилгээтэй төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлэг хяналтын комиссын зөвлөлгөөнөөс тогтоож, дүгнэлт гаргуулсан иргэн санхүүгийн дэмжлэг авах тухай хүсэлтээ эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн</p>

			<p>захиргааны төв байгууллагад тавина.</p> <p>2.2. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох алба нь гадаад оронд оношилгоо, эмчилгээ хийлгэх хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг хүлээн авч судлах, шаардлагатай бол холбогдох эмнэлгийн байгууллагаар нарийвчлан судлуулж саналаа Зөвлөлийн хуралд оруулна.</p> <p>2.3. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар гаргасан Зөвлөлийн хурлын шийдвэрийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулж уг тушаалын хувийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.</p> <p>2.4. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу Сангийн яамны Төрийн сангийн газар эрүүл мэндийн сайдын төсвийн багцаас ажлын 5 өдөрт багтаан эмчлүүлэгчийн нэр дээр мөнгийг шилжүүлнэ.</p>
3	<p>Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар чиглэл өгөх тухай 2014.06.17 №:06</p>	1.23.Эрүүл мэндийн салбарын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол /1-23 дугаар заалт бүгд/	Эрүүл мэндийн салбарын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 23 заалт бүхий тогтоолыг хяналтандаа авч Хавсралтанд заагдсан тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т 2016 оны 5 дугаар сарын 27-нд 3/2271 тоотой хүргүүлсэн.
4	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014.10.29 №:08</p>	<p>10.Цэргийн дүйцүүлэх алба хааж буй иргэдийг оршин суугаа нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах.</p> <p>9.Орон нутагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, сумдын хэсгийн төлөөлөгч, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн тасгийг унаа, автомашинаар хангах.</p>	<p>Цэргийн дүйцүүлэх алба хааж буй иргэдийг оршин суугаа нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд татан оролцуулж байна.</p> <p>Орон нутагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, сумдын хэсгийн төлөөлөгч, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн тасгийг унаа, автомашинаар хангах арга хэмжээг тухай бүр авч байна.</p>
5	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014.12.17 №:09</p>	1.1.Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай аймгийн нутгийн удирдах байгууллагуудын хуульд нийцээгүй 1738 шийдвэрийг хуульд	1.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны захиалгаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар

		<p>нийцүүлэх арга хэмжээг авах, энэ хугацаанд тухайн шийдвэрүүдэд дурдсан газруудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохыг түдгэлзүүлэх;</p>	<p>нутгийн сүлжээ” төслийн хүрээнд “Геоботаник” ХХК-иар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээний 1:100 000 масштабтай байрзүйн тоон зурагт газарзүйн холболт хийж ажлын суурь зургийг бэлтгэх, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хил давхцал, ашигт малтмалын лицензийн талбайтай орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хил давхцал, орон нутгийн тусгай хамгаалалттай газар өөр хоорондоо огтлолцсон давхцал, сум аймгийн тогтоолоор ирсэн координат аймаг, сумыг дамнаж орших, орон нутгийн тусгай хамгаалалттай газар буруу зурагдсан, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эргэлтийн цэгийн зарим координатыг буруу тодорхойлсон зэрэг зөрчил дутагдлыг арилгах зорилгоор гэрээт ажлыг гүйцэтгүүлж, давхацсан буюу зөрчилтэй газар-927, газар нутгийн зөрчлийг арилгасан 1744 шийдвэрийг хуульд нийцүүлэн, нийт 2179 шийдвэрийг гаргуулж ажиллан, холбогдох тайлан танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлж ажилласан.</p>
		<p>1.4.1. Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах Цагаан дэлийн агуйг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах, байгаль орчинд учирсан хохирлыг тооцож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авах, уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас хохирсон иргэдэд нөхөн төлбөр олгох, эрх ашгийг хамгаалах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;</p> <p>1.4.2. Дэлгэрэх сумын нутагт байрлах Чандмань хар уулын тусгай хамгаалалтад авсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тус суманд хууль зөрчин явуулж буй бичил уурхайн үйл ажиллагааг зогсоох, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох;</p>	<p>1.4.1. Улсын тусгай хамгаалалтад 1 840 267.59 га талбайг шинээр авах 7 газрын Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/1068 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Дорноговь аймгийн Айраг суманд байрлах Цагаан дэлийн агуй багтсан болно.</p> <p>1.4.2. Дорноговь аймгийн Хөвсгөл суманд орших Хутаг Уулын МУ-017663 дугаартай ашигт малтмал эзэмшигч “Галакси Майнинг Монголиа” ХХК юм. БНМАУ-ын Дорноговь аймгийн Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 1988 оны 99 дүгээр тогтоолоор “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар”-тай давхцалтай байсан байна.</p> <p>Уул уурхайн сайд болон БОНХАЖ-ын сайдын хамтарсан 220/А/363 тушаалаар 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд дараах дүгнэлтийг гаргасан болно. Үүнд: Тухайн орон нутаг, АМГ болон тухайн үеийн Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны</p>

		<p>1.4.3. Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хутаг уулыг орчны байгаль, түүх, соёлын дурсгалт газруудын хамт улсын тусгай хамгаалалтад авах;</p>	<p>төв байгууллагад орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн солбилцол өгөөгүй байсан байна.</p> <p>“Галакси майнинг Монголиа” ХХК-ийн ТЭЗҮ-г нарийвчлан шалгаж, Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн далд аргаар ашиглаж болох эсэхийг судалж үзэх шаардлагатай гэж дүгнэв.</p> <p>Тусгай зөвшөөрлийг цуцлан, нөхөн төлбөр олгох талаар судлахыг АМГ үүрэг болгосон болно.</p> <p>1.4.3. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, ШУА-ын Газарзүйн хүрээлэн, олон улсын байгууллагуудтай хамтран тусгай хамгаалалтад авах газруудын жагсаалтыг 2016-2030 он хүртэл 4 судалгааны бүсд ангилан гүйцэтгэж дуусган, ЗГХЭГ-т хүргүүлээд байна.</p> <p>Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хутаг уулыг нэн тэргүүнд буюу 2017 онд хамгаалалтад авах шаардлагатай газрын жагсаалтад орсон болно.</p>
5	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай</p> <p>2015.02.18 №:05</p>	<p>1.1.Монгол Улсын иргэдэд олгосон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдах хүсэлт гаргасан боловч төлбөр төлөгдөөгүй буюу хишиг хувь хүртээгүй иргэдийн хувьцааг буцаан эзэмшүүлэх, хөрөнгийн болон хувьцааны бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн цэгцэлж, нийт хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүдийн эзэмшлийн хувьцааг баталгаажуулах арга хэмжээ авах,</p>	<p>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас 2012 онд явуулсан судалгаагаар хувьцаагаа Засгийн газарт худалдах буюу 1.0 сая төгрөгөө бэлнээр авах иргэн 1,120,285 гарчээ. Засгийн газраас аж ахуйн нэгжид худалдсан хувьцааны орлогоос иргэдээс худалдан авах хувьцааны төлбөрийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн ч иргэдийн хүсэлт 1.1 их наяд төгрөгийг аж ахуйн нэгжид хувьцаа худалдсан 29.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх боломжгүй болж, иргэдэд хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр эзэмшүүлэхээр байсан.</p> <p>Гэсэн хэдий ч Засгийн газрын 2012 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 3.11-д Засгийн газарт худалдах иргэдийн хувьцааг хасч, бүртгэл хөтлөхөөр заасны дагуу ҮЦТТТХТ ХХК нь 1.0 сая төгрөг авах өргөдөл гаргасан 1,120,285 иргэний 1,200,607,304 ширхэг хувьцаа, 1.0 сая төгрөгөөс бага, хувьцааны төлбөр аваад хувьцаагаа зарах хүсэлт гаргасан 383,699 иргэний 383,021,152 ширхэг буюу нийт 1,503,984 иргэнд ногдох 1,583,628,456 ширхэг хувьцааг хасч тооцон Төрийн мэдлийн дансанд бүртгэсэн байна</p>

			<p>(ҮЦТТТХТ ХХК-ийн 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр ирүүлсэн тайлан мэдээг үндэслэв).</p> <p>2015 он гарснаар хувьцаа эзэмшлийн асуудлаар иргэдээс олноор өргөдөл, гомдол гаргах болж, улмаар УИХ-ын Өргөдлийн байнгын хорооноос Засгийн газарт иргэдийн нэр дээр хувьцааг буцаан бүртгэх асуудлыг шийдвэрлэх чиглэл болгосон.</p> <p>Энэ чиглэлээр Засгийн газрын 2015 оны 151 дүгээр тогтоол гарч, хүсэлт гаргасан ч мөнгөө аваагүй 1,503,984 иргэний 1,583,628,456 ширхэг хувьцааг төрийн мэдлийн данснаас иргэдийн нэр дээр буцаан бүртгэсэн байна.</p> <p>Ингэснээр иргэдийн эзэмшиж буй хувьцаа нийт хувьцааны 17.05 хувь болсон байна (ҮЦТТТХТ ХХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01/770 албан бичгээр ирүүлсэн мэдээг үндэслэв).</p>
7	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай</p> <p>2015.06.13 №: 11</p>	<p>1. Боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг тогтвортой, тууштай хэрэгжүүлэх</p>	<p>Боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг тогтвортой, тууштай хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурал 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулиудад энэхүү Байнгын Хорооны тогтоолд заасан Боловсролын тухай хуулийн 11. дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 12, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 дэх заалтад дараах байдлаар холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж баталсан.</p> <p>Үүнд:</p> <p>Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн “11.2.Боловсролын стандарт нь багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно.”, “11.3.стандартыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлнэ.”,</p>

			<p>39 дүгээр зүйлийн “39.12.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.” гэж, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн “6.2.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу зохион байгуулна.” гэж, “7.1.Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж, “7.2.Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ.” гэж, “8.6.Тусгай, гэр цэцэрлэг болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.” гэж, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.9.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж, 4 дүгээр зүйлийн “4.1.16.“салбар бүлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг цэцэрлэгт түшиглэн эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрээр эрүүл, аюулгүй, хамгаалагдсан, стандартад нийцсэн сургалтын орчин бүхий хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагааг.” гэж, 35 дугаар зүйлийн “35.4.9.сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх;” гэсэн агуулгаар тусгагдсан болно.</p>
--	--	--	--

		<p>2. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж, боловсролын сургалтын байгууллагын эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглах, шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрын хэмжээг сургалт, судалгаа, туршилтын үйл ажиллагаа явуулах, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжтой байхаар тогтоож байх</p>	<p>Боловсролын тухай хуульд зааснаар сургалтын байгууллагын эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглахад анхаарч холбогдох байгууллагад энэ чиглэлээр чиглэл, зөвлөмж өгч ажиллаж байгаа бөгөөд шинээр барих сургалтын байгууллагын орчин, эзэмшил газрын хэмжээг сургалт, судалгаа, туршилтын үйл ажиллагаа явуулах, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжтой байх орчныг бүрдүүлэх шаардлага тавин барилга байгууламж бариулах ажлыг зохион байгуулж байна.</p>
		<p>3. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т заасныг хэрэгжүүлэх, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгыг нэн тэргүүнд тавьж, шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх, хувийн сургууль, цэцэрлэгийг байгуулахад боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д заасан зарчмын хүрээнд төрөөс зохих дэмжлэг үзүүлэх, өдөр өнжүүлэх үйлчлэгээг зохицуулсан эрх зүйн орчныг бий болгох</p>	<p>2016 онд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт нийт 50 барилга шинээр ашиглалтанд оруулсан ба үүнээс сургуулийн барилга 20, их дээд сургуулийн барилга 1, цэцэрлэгийн барилга 13, сургуулийн дотуур байрны барилга 6, соёлын салбарын барилга 6, спортын салбарын барилга 3, шинжлэх ухааны салбарын барилга 1 тус тус хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан ба тухайн сургууль, цэцэрлэг, соёл, шинжлэх ухаан, спортын барилгын эдэлбэр газрыг стандартын дагуу олон нийтийн эзэмшил мөн сургалтын үйл ажиллагаа явуулах, сургалт хүмүүжлийн ажил гүйцэтгэх чиглэлээр эдэлбэр газрыг тогтоож ашиглагч байгууллагад эзэмшүүлэн олгосон байна.</p>
		<p>4. Малчдын 6 настай хүүхдэд боловсрол эзэмшүүлэхдээ амьдрах орчин, асран хамгаалах боломж нөхцлийг бүрдүүлэх, ерөнхий боловсролын сургуульд анх элсэн орохдоо насны сонголттой байхаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	<p>Улсын Их Хурал 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.9-д “35.4.9.сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх;” гэж нэмэлт оруулж баталсан болно.</p>
		<p>9. Хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд мэрэгжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгах</p>	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн тус яаманд ирүүлэх тухай бүр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх арга хэмжээг авч байсан болно.</p>
<p>8</p>	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай</p>	<p>2.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх хүрээг өргөжүүлэх талаарх иргэдийн хүсэлт болон гэр</p>	<p>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооллын инженерийн шугам сүлжээнд 3.2 тэрбум, Сонгинохайрхан дүүргийн</p>

	<p>2015.06.17 №: 12</p>	<p>хорооллыг орон сууцжуулах төсөл нь урт, дунд хугацаанд хэрэгжих зэргийг харгалзан инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлыг төсөл хэрэгжих хугацаатай уялдуулан төлөвлөж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулж ажиллах</p>	<p>Баянголын амны инженерийн шугам сүлжээнд 140.0 сая, Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын инженерийн шугам сүлжээнд 2.7 тэрбум, Буянт-Ухаа орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээнд 9.8 тэрбум, Ирээдүй цогцолбор хорооллын инженерийн шугам сүлжээнд 690.8 сая, Яармагийн гүүр орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээнд 940.0 сая, Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо-Ханын материал орчмын гэр хорооллын инженерийн шугам сүлжээнд 678.6 сая төгрөгийг Хөгжлийн банкнаас тус тус санхүүжүүлэхээр 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдаад байна.</p> <p>Мөн БНХАУ-ын 300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын VII, XIV хороололд баригдах орон сууцны барилга, VII хороолол, МҮОНРТ-ийн орчимд баригдах орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээнд 17.9 тэрбум төгрөгийг БНХАУ-ын Экзим банкнаас санхүүжүүлэхээр 2017 оны төсвийн тухай хуулиар батлагдаад байна.</p>
		<p>7. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ач холбогдолыг иргэдэд тайлбарлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй явуулж, эерэг хандлага төлөвшүүлж дахин төлөвлөлт хийхээр батлагдсан байршилд төсөлд оролцошч иргэдийн эрх, үүргийн талаарх мэдээллийг оршин суугчдад ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэж, тухайн дүүрэг, хорооны холбогдох албан тушаалтнууд дахин төлөвлөлтийн асуудлаар сургалт зохион байгуулж, ажлын уялдааг хангахад анхаарах</p>	<p>Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, БХБЯам болон НЗДТГ-тай хамтран 2015 оноос эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь үе шатны төслийн хүрээнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор холбогдох сургалт, семинар зохион байгуулж, гарын авлага, видео танилцуулга хийж, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль болон хуулийг дагалдаж батлагдсан дүрэм, журмыг сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулж Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016.03.24-ний өдрийн 45-А/239 дүгээр хамтарсан тушаал, захирамжаар байгуулсан Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын техникийн туслалцааны “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний чадавхийг</p>

			<p>сайжруулах” дэд төсөл-1 болон ”Монгол Улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шат” дэд төсөл-2-ийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төслүүдийн хэрэгжилт, үр дүнгийн явцыг хянах чиг үүрэг бүхий Төслийн хамтарсан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн шинээр Төслийн удирдах хороо Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан 2016.09.22-ны өдрийн 155/ А-675 дугаар тушаал, захирамжаар байгуулсан.</p> <p>2016.10.07-ны өдөр төслийн Удирдах хорооны 5 дахь удаагийн хурлыг зохион байгуулсан.</p> <p>”Монгол Улсын Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шат” дэд төсөл-2-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, өдөр тутмын удирдлага, бодлого, зөвлөмжөөр хангах чиг үүрэг бүхий БХБЯ-ны ХБГХБГ-ын даргаар ахлуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг БХБ-ын сайдын 2016.03.24-ний өдрийн 44 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж ажиллаж байна.</p>
9	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай</p> <p>2015.12.01 №: 15</p>	<p>1. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Тост, тосон бумбын нуруу орчим нутгийн байгалийн унаган тогтолцоо, шим ертөнцийн бүрэн бүтэн байдал, дэлхийд ховор ан амьтан, ургамал, экосистемийн бүрдлийг хадгалах зорилгоор тус газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай улсын ич хурлын тогтоолын төслийг 2015 оны 12 дугаар сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх</p>	<p>Улсын Их Хурлын Улсын Их Хурлын 2016 оны 04 сарын 14 өдрийн 35-р тогтоолоор Тост, Тосон бумбын нурууг байгалийн нөөц газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтад авсан бөгөөд тогтоолын төслийн биелэлтийг хангах зорилгоор олон нийтэд сурталчилах ажлын хүрээнд байгаль орчны мэдээллийн санд бүртгэн, олон нийтэд таниулан сурталчилж ажиллаа.</p> <p>Тост, тосон бумбын нурууны БНГ-ын хамгаалалтын менежментийг Ирвэс хамгаалах ТТБ-д хариуцуулан ажиллахаар хамтран ажиллаж байна.</p> <p>Тусгай хамгаалалтад авсан газрын хилийн заагийг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдуудаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2016 оны 04.22-ны 01/2364 албан тоотоор холбогдох материалын хамт хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдуудаас санал авч бэлтгээд</p>

			байна. Ашигт малтмал, Газрын тосны газарт 2016.09.14-ны өдрийн 03/900 тоотор УИХ-ын тогтоолын 2 дахь хэсэгт “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь заалтын дагуу Монгол Улсын Засгийн газар хилийн заагийг тогтоохыг даалгасан”-ны дагуу хилийн цэсийг тогтоох ажлын хүрээнд тогтоож буй хилийн бүст хамрагдаж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн нөхөх олговрыг тооцуулахаар хүргүүлэн тооцоо судалгааг нэгтгэн дүгнэсэн болно.
10	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.12.21 №: 05	7. Аж ахуй нэгжид ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, хугацааг сунгахад уул уурхайн үйл ажиллагаа явуулах чадавхи, мэрэгжлийн боловсон хүчинтэй байх шаардлагыг харгалздаг байх	Уул уурхайн үйл ажиллагаа явуулах чадавхи, мэрэгжлийн боловсон хүчинтэй байх шаардлагыг харгалзаж Аж ахуй нэгжид ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, хугацааг сунгах үйл ажиллагааг явуулж байна.
Нийт 10 тогтоолын 21 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн болно.			